#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт   | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | /төгрөг/               |   |
|-----|--|---------------------------------|-----------------------|------------------------|---|
|     |  |                                 |                       | Хуримтлагдсан дүн      | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
| C01 | <b>2021 оны 1-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>      | 269,826,812.00                  | 343,439,188.91        | -297,790,879.91        | 315,475,121.00                          |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт       | 00.00                           | 00.00                 | 20,728.85              | 20,728.85                               |
| C03 | <b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>                | <b>269,826,812.00</b>           | <b>343,439,188.91</b> | <b>-297,770,151.06</b> | <b>315,495,849.85</b>                   |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт          | 00.00                           | 00.00                 | 00.00                  | 00.00                                   |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт        | 00.00                           | 00.00                 | 00.00                  | 00.00                                   |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз    | 00.00                           | 00.00                 | 00.00                  | 00.00                                   |
| C07 | Тайлант үеийн үр дүн                             | 8,988,000.00                    | 00.00                 | 33,370,869.44          | 42,358,869.44                           |
| C08 | <b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>     | <b>278,814,812.00</b>           | <b>436,749,107.32</b> | <b>406,249,775.54</b>  | <b>1,121,813,694.86</b>                 |
| D01 | <b>2022 оны 1-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>      | <b>278,814,812.00</b>           | <b>436,749,107.32</b> | <b>406,249,775.54</b>  | <b>1,121,813,694.86</b>                 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт       | 00.00                           | 00.00                 | 00.00                  | 00.00                                   |
| D03 | <b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>                | <b>278,814,812.00</b>           | <b>436,749,107.32</b> | <b>406,249,775.54</b>  | <b>1,121,813,694.86</b>                 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00                           | 00.00                 | 00.00                  | 00.00                                   |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт                  | 00.00                           | 00.00                 | 00.00                  | 00.00                                   |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз    | 00.00                           | 00.00                 | 00.00                  | 00.00                                   |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн                     | 00.00                           | 00.00                 | 00.00                  | 00.00                                   |

|     |                                       |                |                |                |                  |
|-----|---------------------------------------|----------------|----------------|----------------|------------------|
| D08 | Тайлант үеийн үр дүн                  | 00.00          | 00.00          | 27,799,370.52  | 27,799,370.52    |
| D09 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 278,814,812.00 | 436,749,107.32 | 434,049,146.06 | 1,149,613,065.38 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт   | Тайлант оны           |                |               |
|-----------------------|--|-----------------------|----------------|---------------|
|                       |  | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл      | Зөрүү         |
| 1                     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл           |                       | 2822142.06     | 2822142.06    |
| 2                     | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                   | 770,247,000.00        | 691,932,911.94 | -78314088.06  |
| 21                    | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                       | 770,247,000.00        | 691,932,911.94 | -78314088.06  |
| 210                   | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                     | 730,247,000.00        | 671,932,911.94 | -58314088.06  |
| 2101                  | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                   | 429,610,300.00        | 380,291,371.88 | -49318928.12  |
| 210101                | Үндсэн цалин   | 381,965,300.00        | 266,633,947.61 | -115331352.39 |
| 210102                | Нэмэгдэл   | 00.00                 | 75,342,472.53  | 75342472.53   |
| 210103                | Унаа хоолны хөнгөлөлт                                      | 5,808,000.00          | 4,524,998.30   | -1283001.70   |
| 210104                | Урамшуулал   | 36,797,000.00         | 33,042,824.64  | -3754175.36   |
| 210105                | Гэрээт ажлын хөлс  | 5,040,000.00          | 747,128.80     | -4292871.20   |
| 2102                  | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>      | 53,701,200.00         | 46,541,642.06  | -7159557.94   |
| 210201                | Тэтгэврийн даатгал   | 36,516,900.00         | 32,007,205.61  | -4509694.39   |
| 210202                | Тэтгэмжийн даатгал   | 4,296,100.00          | 3,765,589.30   | -530510.70    |
| 210203                | ҮОМШӨ-ний даатгал  | 3,436,900.00          | 3,012,411.09   | -424488.91    |
| 210204                | Ажилгүйдлийн даатгал                                       | 859,100.00            | 709,773.74     | -149326.26    |
| 210205                | Эрүүл мэндийн даатгал                                      | 8,592,200.00          | 7,046,662.32   | -1545537.68   |
| 2103                  | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>           | 32,288,100.00         | 30,441,472.00  | -1846628.00   |
| 210301                | Гэрэл, цахилгаан   | 3,750,000.00          | 2,303,331.00   | -1446669.00   |
| 210302                | Түлш, халаалт  | 28,218,100.00         | 28,138,141.00  | -79959.00     |
| 2104                  | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                    | 61,144,600.00         | 50,878,240.00  | -10266360.00  |
| 210401                | Бичиг хэрэг  | 3,350,000.00          | 3,502,400.00   | 152400.00     |
| 210402                | Тээвэр, шатахуун   | 38,851,400.00         | 34,306,240.00  | -4545160.00   |
| 210403                | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                         | 5,372,500.00          | 1,735,000.00   | -3637500.00   |
| 210405                | Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал | 1,870,700.00          | 1,792,500.00   | -78200.00     |
| 210406                | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                | 11,675,100.00         | 9,542,100.00   | -2133000.00   |
| 2105                  | <b>Нормативт зардал</b>                                    | 107,154,300.00        | 129,958,796.00 | 22804496.00   |
| 210501                | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл                            | 77,167,000.00         | 102,036,756.00 | 24869756.00   |
| 210502                | Хоол, хүнс   | 25,237,400.00         | 23,684,040.00  | -1553360.00   |
| 210503                | Нормын хувцас, зөөлөн эдлэл                                | 4,749,900.00          | 4,238,000.00   | -511900.00    |
| 2106                  | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                   | 38,866,200.00         | 30,428,720.00  | -8437480.00   |
| 210601                | Багаж, техник, хэрэгсэл                                    | 11,577,100.00         | 9,832,700.00   | -1744400.00   |
| 210602                | Тавилга  | 5,401,400.00          | 4,110,520.00   | -1290880.00   |
| 210604                | Урсгал засвар  | 21,842,800.00         | 16,485,500.00  | -5357300.00   |
| 2107                  | <b>Томилолт, зочны зардал</b>                              | 2,038,000.00          | 1,006,000.00   | -1032000.00   |
| 210702                | Дотоод албан томилолт                                      | 2,038,000.00          | 1,006,000.00   | -1032000.00   |

|         |  |                |                |              |
|---------|--|----------------|----------------|--------------|
| 2108    | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,230,100.00   | 1,496,570.00   | -733530.00   |
| 210802  | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                 | 828,000.00     | 738,000.00     | -90000.00    |
| 210803  | Даатгалын үйлчилгээ                                      | 180,000.00     | 180,000.00     | 0.00         |
| 210804  | Тээврийн хэрэгслийн татвар                               | 227,400.00     | 132,010.00     | -95390.00    |
| 210805  | Тээврийн хэрэгслийн оношлогоо                            | 162,800.00     | 88,000.00      | -74800.00    |
| 210806  | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                          | 650,000.00     | 253,000.00     | -397000.00   |
| 210807  | Газрын төлбөр  | 106,900.00     | 105,560.00     | -1340.00     |
| 2109    | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 3214200.00     | 890100.00      | -2324100.00  |
| 210901  | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 3,214,200.00   | 890,100.00     | -2324100.00  |
| 213     | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 40000000.00    | 20000000.00    | -20000000.00 |
| 2132    | Бусад урсгал шилжүүлэг                                   | 40,000,000.00  | 20,000,000.00  | -20000000.00 |
| 213209  | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                  | 40,000,000.00  | 20,000,000.00  | -20000000.00 |
|         | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                    | 770,247,000.00 | 737,913,094.06 | -32333905.94 |
| 1320    | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                    | 33,788,100.00  | 31,590,772.00  | -2197328.00  |
| 132001  | Орон нутгийн төсвөөс                                     | 33,788,100.00  | 31,590,772.00  | -2197328.00  |
| 1340    | <b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>      | 732,373,900.00 | 703,500,180.00 | -28873720.00 |
| 134002  | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих                | 732,373,900.00 | 703,500,180.00 | -28873720.00 |
| 120004  | <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>             | 00.00          | 2,822,142.06   | 2822142.06   |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих                            | 00.00          | 2,822,142.06   | 2822142.06   |
| II      | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                    |                |                | 0.00         |
| 1311    | Нэмэлт санхүүжилтийн орлого                              | 4085000        | 4,085,000.00   | 0.00         |
| 4       | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл         | 00.00          | 2,822,142.06   | 2822142.06   |
| 5       | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл        | 00.00          | 50,065,182.12  | 50065182.12  |
| 62      | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>                                  | 23.00          | 23.00          | 0.00         |
| 620001  | Удирдах ажилтан  | 01.00          | 01.00          | 0.00         |
| 620002  | Гүйцэтгэх ажилтан  | 15.00          | 15.00          | 0.00         |
| 620003  | Үйлчлэх ажилтан  | 07.00          | 07.00          | 0.00         |

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өлгий сумын Эрүүл мэндийн төв нь үйлчлүүлэгчдэд ээлтэй, чанартай, тэгш хүртээмжтэй, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэн, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулж, өвчлөл эндэгдлийг бууруулахад чиглэн үйл ажиллагаагаа явуулж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Үүнд:

- ✓ Эрүүл мэндийн тухай хууль - 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан.
- ✓ Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль - 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан.

- ✓ Эрүүл мэндийн даатгалын тухай хууль - 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан.
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф" тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15,189.8 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл    | Өөрчлөлт        |
|---|--------------------|--------------------|-----------------|
| Б   | 1                  | 2                  | 3=2-1           |
| Мөнгөн хөрөнгө                                    | 2,822.1            | 50,065.8           | 47,243.7        |
| Авлага  | 47,225.0           | 3,014.0            | 44,211.0        |
| Урьдчилгаа  | 0.0                | 0.0                | 0.0             |
| Бараа материал                                    | 124,025.9          | 192,868.4          | 68,842.5        |
| Үндсэн хөрөнгө                                    | 958,689.2          | 903,735.5          | 54,953.7        |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b>1,132,762.2</b> | <b>1,147,952.1</b> | <b>15,189.8</b> |
| Өр төлбөр   | 10,948.5           | 0                  | -10,948.5       |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/               | 1,121,813.7        | 1,147,952.0        | 26,138.3        |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>1,132,762.2</b> | <b>1,14,952.0</b>  | <b>15,189.8</b> |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 47,243.7 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн шинэчлэл хэрэгжиж улсын төсвөөс санхүүжиж буй байгууллагуудын дансны үлдэгдлийг татан төвлөрүүлэхгүй байх шийдвэр хэрэгжсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 3,014.0 төгрөг болж буурсан нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлагаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 192,868.4 мянган төгрөг болж 68,842.5 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар ирсэн бараа материалаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 903,735.5 мянган төгрөг болж 54,953.7 мянган төгрөгөөр буурсан нь шинээр 17,634.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, 18,500.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл хасагдаж, хөрөнгийн элэгдлийн зардал өссөн нь нөлөөлсөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 10,948.5 мянган төгрөгийн өр төлбөрийг бүрэн барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,147,952.0 мянган төгрөг болж 26,138.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 622,007.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 81,493.2 мянган төгрөгөөр нэмэгдэж 703,500.2 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 691,416.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 33,788.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 657,628.3 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 33,788.1 мянга, Эрүүл мэндийн даатгалын сангаас 657,628.2 мянга, нийт 691,416.3 мянган төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаанд 713,943.4 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 2,197.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | /мянган төгрөгөөр/ |         |
|-----|-----------------------|------------|-----------|--------------------|---------|
|     |                       |            |           | Зөрүү              | Биелэлт |
|     | Улсын төсвөөс         | 679,781.4  | 660,342.1 | 19,439.3           | 97.1%   |
|     | Орон нутгийн төсвөөс  | 33,788.1   | 33,788.1  | 0                  | 100%    |

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 660,342.1 мянган төгрөг буюу 97.1 хувьтай байгаа нь цалин урамшууллын зардлыг 42,743.5 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 6,106.9 мянга, багаж техник хэрэгслийн зардлыг 1,744.4 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 2,301.8 мянга, бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээний төлбөрийн зардлыг 961.2 мянга, хангамж, бараа материалын зардлыг 3,535.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсан байна. Түүнчлэн эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилт 50,065.2 мянган төгрөгийг бүрэн авсантай холбоотой байна.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлага гараагүй байна.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Өлгий сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Увс Финанс Аудит” ХХК-ийн аудитор Я.Тунгалаг гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Я.Нарантуяа, чанарын хяналтыг Увс аймгийн Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Увс Финанс Аудит” ХХК –д 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 06 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 755.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 7.5 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 715.2 сая төгрөгийн 1 хувиар буюу 7.1 сая төгрөгөөр тогтоосон.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн хувьд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хамаарах зүйл заалтын хүрээнд зөрчил гараагүй байна. /АБ-4/

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаа хоцроож 29, хугацаандаа оруулсан 120 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилт

Өлгий сумын Эрүүл мэндийн төв нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### АУДИТЫН ТАЙЛАНГ


ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

“УВС ФИНАНС АУДИТ” ХХК-ИЙН  
АУДИТОР 

/Я.ТУНГАЛАГ/

2023 оны 02 дугаар сарын 13-ны өдөр